



МОНГОЛ УЛСЫН ЗАСГАЛЫН ГЯЛГАМЖИРГАХ, ДААТГАЛЫН Г

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

16100 Улаанбаатар Уул, Чингэлтэй дүүрэг,
Баянхошуу-13, Утас: 33 83 30, Факс: (9744) 33 01 13,
E-mail: andag@andag.gov.mn, andag@andag.gov.mn

2022.01.11 01/20
Тангил _____ -ны № _____ -т

АЙМАГ (НИЙСЛЭЛ), ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
(ГАЗАР)-ИЙН ДАБГА НАРТ

2022 оны төсвийн хуваарь
хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны "2022 оны төсвийн хуваарь батлах тухай" 23 дугаар тогтоолоор баталсан аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2022 оны төсвийн хуваарь, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны "Төсвийн хуваарь батлах тухай" А/03 дугаар тушаалаар баталсан аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2022 оны төсвийн сар, улирлын хуваарийг тус тус хүргүүлж байна.

Иймд батлагдсан төсвийг дахин хуваарилах, нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлтийг сайжруулах, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд, даатгуулагчдад шуурхай хүргэх, төсвийг батлагдсан төсвийн хүрээндүр ашигтай зарцуулах чиглэлээр дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгож байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн талаар: Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын санд төсвийн жилд төвлөрүүлэх орлогын хэмжээг 2,379.5 тэрбум, сангийн зарлагын хэмжээг 2,751.0 тэрбум, улсын төсвийн санхүүгийн дэмжлэгийг 459.9 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлгийг 1.1 тэрбум төгрөгөөр тус тус баталсан болно. Иймд төсвийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дараах асуудлыг анхаарвал зохино. Үүнд:

1.1 Хүн амын болон ажил олгогчийн нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч, 2021 оны хүрсэн түвшингээс ажил олгогчийн тоог 5.0 хувь, даатгуулагчдын тоог 2.5 хувь, сайн дурын даатгуулагчдын тоог 10.0-аас доошгүй хувиар нэмэгдүүлж, малчдын сайн дурын даатгалын хамралтыг 30-аас доошгүй хувьд хүргэх, хөдөлмөрийн гэрээ бүхий туслах малчныг сайн дурын даатгалд бүрэн хамруулах;

1.2 Аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2022 оны орлогын төлөвлөгөөг сум, ажил олгогчийг хариуцан ажиллаж байгаа байцаагч бүрээр хуваарилан жигд ханган биелүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 2022 оны эхний үлдэгдлээс 30-аас доошгүй хувиар барагдуулахад онцгой анхаарч холбогдох арга хэмжээ авч ажиллах;



1.3 Засгийн газрын 2021 оны “Ажилгүйдлийн даатгалын сангаас сургалтад хамрагдах нэг даатгуулагчид олгох зардлын дээд хэмжээг тогтоох тухай” 361 дүгээр тогтоолоор зардлын дээд хэмжээг 150.0 мянган төгрөгөөр шинэчлэн баталсны дагуу ажилгүйдлийн даатгалын сангаас сургалтын зардал олгохдоо уг хэмжээ болон батлагдсан төсвийг баримтлах;

1.4 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих сувиллын хувьсах зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 16 дугаар тогтоолоор хувьсах зардлын нэг ор хоногийн хэмжээг 60.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосныг баримтлан гэрээ бүхий сувиллуудад төсвийн дагуу санхүүжилт олгох;

1.5 Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны “Жишиг үнийн жагсаалт шинэчлэн батлах тухай” А/507, А/112 дугаар хамтарсан тушаалаар баталсан жишиг үнийн жагсаалт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид хиймэл эрхтэн, засал эмчилгээ /протез, ортопед/-ний төлбөр олгоход баримтлах заавар”-ыг баримтлан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагчид протез, ортопедийн үнийг батлагдсан төсвийн хүрээнд олгох.

2. Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2022 оны төсвийн талаар: Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг 32,362.6 сая.төгрөгөөр баталсан болно. Иймд үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг хэрэгжүүлэхэд дараах зүйлийг анхаарвал зохино. Үүнд:

2.1 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны “Орон тоо батлах тухай” А/112 дугаар тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны “Бүтэц, орон тоо батлах тухай” А/22 дугаар тушаалаар баталсан нийгмийн даатгалын байгууллагуудын орон тооны дээд хязгаарыг баримтлан цалингийн болон үйл ажиллагааны бусад урсгал зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, төсвийн сахилгыг мөрдөж ажиллах;

2.2 Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2022 оны төсөвт ТҮ-3 болон түүнээс доош албан тушаалын зэрэглэлтэй албан хаагчдын орон тоо хасагдаж, цалин хөлс, нэмэгдэл болон ажил олгогчийн хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн төсвийг (2108) кодтой “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж буюу Байр ашиглалтын үйлчилгээний зардал”-ын төсөвт хуваарилан ирүүлсэн боловч Сангийн яамнаас энэ шийдвэрээ өөрчлөн орон тоог буцаан нэмж, цалин хөлс болон хэмэгдэл урамшууллыг (2101) кодтой “Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал” ангиллын зардалд, нийгмийн даатгалын шимтгэлийг (2102) кодтой “Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл” ангиллын зардлын төсөвт буцаан шилжүүлсэн тул орон тоо болон үйл ажиллагааны зардлын төсөвт өөрчлөлт ороогүйг анхаарч ажиллах;



2.3 Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны "Зарим нормативыг шинэчлэн тогтоох тухай" А/173 дугаар тушаалаар нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын унаа, хоолны хөнгөлөлтийн хэмжээг ажлын нэг едэрт нийслэл хотод 8000 төгрөг, аймагт 6000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон тул уг хэмжээг мөрдөж, батлагдсан төсвийн дагуу ажилтнуудад олгох;

2.4 Ажил олгогчийн хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан хувь хэмжээ буюу 12.5 хувиар тооцон хуваарилсан болно. "Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл" ангиллын зардлын төсөвт зөвхөн үндсэн цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулалд ноогдох нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр, харингэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ (төлөөлөгч)-ний цалин хөлс, эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын цагийн хөлс, гомдлын шаардлагын зөвлөлийн цагийн хөлсийн төсвийг нийгмийн даатгалын шимтгэлийн хамтаар "Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж" ангиллаар хуваарилдаг байсныг 2022 онд доор дурдсанаар өөрчлөгдсөнийг анхаарах:

- (2101) кодтой "Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал" ангиллын зардлын төсөвт үндсэн цалин, нэмэгдэл, унаа хоолны хөнгөлөлт, урамшуулал, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ (төлөөлөгч)-ний цалин хөлс, эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын цагийн хөлс, гомдлын шаардлагын зөвлөлийн цагийн хөлс зардлын төсөв багтсан;

- (2102) кодтой "Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл" ангиллын зардлын төсөвт үндсэн цалин, нэмэгдэл, унаа хоолны хөнгөлөлт, урамшуулал, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ (төлөөлөгч)-ний цалин хөлс, эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын цагийн хөлс, гомдлын шаардлагын зөвлөлийн цагийн хөлсэд ноогдох нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсөв багтсан;

Иймд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэхгүй байхад онцгой анхаарч ажиллах;

2.5 Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/174 дүгээр тушаалаар нийгмийн даатгалын төлөөлөгчийн орон тоог шинэчлэн баталсан тул хөдөлмөрийн хөлсний хэмжээ (420.0 мян.төг)-г баримтлан ажиллуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын төлөөлөгч ажиллуулах журам"-д зааснаар тооцон ажиллах;

2.6 2022 онд (210401) кодтой "Бичиг хэрэг", (210702) кодтой "Дотоод албан томиллолт" зардлын төсвийг 50 хувиар бууруулан баталсан тул эдгээр төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулах;


2.7 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлын төсвийг Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2, 46.2.3-т заасан үндэслэлээр 2022 онд төрийн албанаас чөлөөлөгдөж, өндөр насны тэтгэвэр тогтоолгох ажилтнуудын судалгааг үндэслэн хуваарилсан тул Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 7 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг баримтлан төсвийн сарын хуваарийн дагуу олгох;




2.8 Ахмадын сан зардлын төсвийг Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.7-д заасан үндэслэлээр хуваарилсан тул Засгийн газрын 2017 оны "Журам батлах, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ыг баримтлан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

2.9 Шилэн дансны тухай хуулийн хүрээнд аймаг, нийслэл (дүүрэг)-ийн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг шилэн дансны цахим хуудсанд холбогдох журмын дагуу хуулиар тогтоосон хугацаанд нь байршуулж ажиллах зэрэг болно.

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн жилд холбогдох хууль тогтоомж болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүлээсэн үүргээ хариуцлагатайгаар биелүүлж, бүтээлч санаачилгатай, хариуцлагатай ажиллахыг мэдэгдье.







2021 оны 12 сарын 27

дүний 23

2022 оны төсвийн хуваарь батлах тухай


Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн нарийвчилсан хуваарь"-ийг нэгдүгээр хавсралтаар, "Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2022 оны төсвийн хуваарь"-ийг хоёрдугаар хавсралтаар, "Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2022 оны төсвийн хуваарь"-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн хуваарийг нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлж, төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т даалгасугай.

3. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хуулиар тогтоосон хугацаанд олгох, шимтгэлийн авлагыг бууруулах, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг баталсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж гүйцэтгэлд нь хяналт тавьж, төсвийн сахилгыг ханган ажиллахыг нийгмийн даатгалын байгууллагуудын төсвийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

ДАРГА  А.АРИУНЗАЯА

1119276367
521-17001 • СБА1473



**НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УРСГАЛ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

Зардлын төрөл		Мөрийн дугаар	Дүн (мян.төг)
A		Б	35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1	471,668.2
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	2	464,250.2
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	3	372,854.0
	210101 Үндсэн цалин	4	266,182.7
	210102 Нэмэгдэл	5	59,156.3
	210103 Унаа хоолны хөнгөлөлт	6	46,640.0
	210104 Урамшуулал	7	875.0
	Үүнээс		
	Хэлтсийн урамшуулал	8	-
	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ /төлөөлөгч/	9	-
	Зөвлөл, хороо комиссын гишүүдийн ажлын хөлс	10	875.0
	Үүнээс		
	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын зардал	11	-
	Гомдол шаардлагын зөвлөлийн зардал	12	875.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13	46,606.9
	210201 Тэтгэврийн даатгал	14	31,692.6
	210202 Тэтгэмжийн даатгал	15	3,728.6
	210203 УОМШ өвчний даатгал	16	2,982.8
	210204 Ажилгйдлийн даатгал	17	745.8
	210205 Эрүүл мэндийн даатгал	18	7,457.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19	-
	210301 Гэрэл цахилгаан	20	-
	210302 Тvlш, халаалт	21	-
	210303 Цэвэр, бохир ус	22	-
	210304 Байрны түрээс	23	-
2104	Хангамж, бараа материалын зардал	24	15,000.0
	210401 Бичиг хэрэг	25	3,000.0
	Үүнээс		
	Хэлтэс	26	3,000.0
	ЭХМК	27	-
	210402 Тээвэр, шатахуун	28	5,000.0
	Үүнээс		
	Хэлтэс	29	5,000.0
	ЭХМК	30	-
	210403 Шуудан,холбоо, интернэтийн төлбөр	31	4,000.0
	Үүнээс		
	Хэлтэс	32	-
	ЭХМК	33	-
	210405 Хог хаягдал зайлуулах, устгал, ариутгал	34	0.0
	210406 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35	3000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36	3500.0
	210601 Багаж, техник, хэрэгсэл	37	2000.0
	210604 Урсгал засвар	38	1500.0
2107	Томилолтын зардал	39	450.0
	210702 Дотоод албан томилолт	40	450.0
	Үүнээс		
	Хэлтэс	41	450.0
	ЭХМК	42	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43	17839.3
	210801 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил,	44	7000.0
	Үүнээс		
	Мэдээлэл, сурталчилгааны зардал	45	6000.0
	Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	46	1000.0
	Харуул хамгаалалтын зардал	47	0.0
	210802 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	48	6000.0
	210803 Даатгалын үйлчилгээ	49	2000.0
	210804 Тээврийн хэрэгслийн татвар	50	664.3
	210806 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	51	-
	210807 Газрын төлбөр	52	2000.0
	210808 Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	53	175.0
	210809 Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	54	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55	8000.0
	210901 Бараа үйлчилгээний бусад зардал	56	-
	210902 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	57	8000.0
	Үүнээс		
	Хэлтэс	58	8000.0
	ЭХМК	59	-
213	Урсгал шилжүүлэг /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал,	60	7418.0
	213204 Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	61	7418.0
	Бусад тусламж дэмжлэг	62	6118.0
	Үүнээс		
	Бусад тусламж дэмжлэг	63	5000.0
	Ахмадын сан	64	1118.0
	Хуульд заасан үндэслэлээр албан хаагчид олгох нөхөн	65	1300.0
	213207 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	66	0.0
	213209 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	67	0.0
	Үүнээс		
	НДЕГ	68	-
	ЭХМК	69	-
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	70	471668.2
3	Нийгмийн даатгалын сангаас	71	471668.2
4	Эрүүл мэндийн даатгалын сангаас	72	0.0
5	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	73	0.0



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
БАНСЫН ТӨВ ХАМГААГАХ ДАРГААЙН
ТУШААХ

2022 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

2022 оны төсвийн хуваарь батлах тухай


Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн 3.2.4, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, батлагдсан төсвийг хуваарилах журам”-ын 7.4, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны “2022 оны төсвийн хуваарь батлах тухай” 23 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны “Төсвийн хуваарь батлах тухай” 239 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


Нэг. “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн сар, улирлын хуваарь”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2022 оны төсвийн сар, улирлын хуваарь”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


Хоёр. Төсвийн санхүүжилтийг баталсан хуваарийг баримтлан олгож ажиллахыг Санхүү, бүртгэлийн газар /Б.Даваахүү/, төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар /Ц.Ганцэцэг/-т тус тус даалгасугай.

Гурав. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, төсвийн сахилгыг ханган ажиллахыг нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын төсвийг захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Г.Саран/-д үүрэг болгосугай.









НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/173

Улаанбаатар хот

Зарим нормативыг шинэчлэн тогтоох тухай

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, 61 дүгээр зүйлийн 61.1.3, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм"-ийн 3.2.4 дэх заалт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны "Журам батлах тухай" 10 дугаар тогтоолын 2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны "Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай" 190 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын унаа, хоолны хөнгөлөлтийн хэмжээг Нийслэл хотод ажлын нэг өдөрт 8000 /найман мянган/ төгрөг, аймгийн төвд ажлын нэг өдөрт 6000 /зургаан мянган/ төгрөг байхаар тус тус шинэчлэн тогтоосугай.

Хоёр. Энэ тушаалаар баталсан нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын унаа, хоолны хөнгөлөлтийн хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Гурав. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн "Зарим нормативыг шинэчлэн тогтоох тухай" А/117 дугаар тушаалын гуравдугаар хавсралтыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Г.Саран/-д даалгасугай.

ДАРГА
Д.ЗОРИГТ

